



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023
ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ,
ҮР ДҮН**

**ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЖ, ХУУЛЬ, ЖУРМЫН
ДАГУУ ТӨЛӨВЛӨХ ХЭРЭГТЭЙ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/18-ШТА-ГА

2024 оны 5 дугаар сар

БҮЛЭГ.А Төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөсөн, төсвийн тодотголоор 80 ажил нэмэлтээр баталж хэрэгжүүлсэн нь ХО-ын чанар, хэрэгжих хугацаанд нөлөөлөөд зогсохгүй, санхүүжилтийн өр төлбөр үүсгэсэн байна.

А.1. ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-г дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөсөн ч төсвийн тодотголоор аймаг, сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлуудыг баталсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр болон он дамжин хэрэгжих нийт 76,922.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 160 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас Дорноговь аймгийн хөгжлийн 2021, 2022, 2023 оны төлөвлөгөөнд 110 ТАХ, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны /2020-2024/ хөтөлбөрт 160 ТАХ, Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 160 ТАХ, тус тус тусгагдаж, 50 ТАХ нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих нийт 4,422.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас сумын “Хөгжлийн төлөө бид хамтдаа-2” Засаг даргын үйл ажиллагааны /2020-2024/ хөтөлбөрт 37 ТАХ, “Аялал жуулчлалыг дэмжих жил-2023” хөтөлбөрт 8 ТАХ-г тусгаж, 11 арга хэмжээ нь дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдаагүй байна.

Орон нутгийн болон сумын дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй, тухайн шатны төсөв захирагчийн өмчлөлд шилжих боломжгүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, төрийн бусад байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг орон нутгийн хөрөнгө оруулалтад тусгаж баталсан байгаа нь төлөвлөлтийн үр дүнд чиглэсэн байх зарчим хангагдахгүй байна.

А.2. Төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөж, батлуулсан байна.

Аймгийн ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо	АЙМАГ ДОРНОГОВЬ  2023 онд нийт 208 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.	Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо
Барилга, байгууламж-50		Барилга, байгууламж-9
Их засвар, засвар-39		Их засвар, засвар-13
ТЭЗҮ-7		ТЭЗҮ-7
Тоног төхөөрөмж-34		Тоног төхөөрөмж-12
Өмнөх оноос шилжсэн-30		Өмнөх оноос шилжсэн-0
Бусад-0		Бусад-7

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт хууль, тогтоомжид заасан шаардлага хангаагүй 58 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.

А.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэн шаардлагатай, томоохон ТАХ-г цогцоор нь хэрэгжүүлэхээр төлөвлөх шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 64,326.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 128 төсөл, арга хэмжээ батлагдаж, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг аймагт 2 удаа, Замын-Үүд суманд 3 удаа тодотгож, 17,018.9 сая төгрөгийн 80 ТАХ-г нэмж өөрчлөлт оруулан, 81,345.0 сая төгрөгийн 208 ажлыг хэрэгжүүлэхээр баталсан байна. /Хүснэгт №2/

ОНХО-ын 2023 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулсан мэдээлэл

/сая төгрөг/

Төсөв захирагч	Анх батлагдсан төсөл, арга хэмжээ			Тодотгосон төсөл, арга хэмжээ			Нэмэгдсэн төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймаг	108	61,759.1	41,194.2	160	76,922.8	52,314.7	52	15,163.7	11,120.5
Замын-Үүд сум	20	2,567.0	2,548.0	48	4,422.2	4,231.0	28	1,855.2	1,683.0
Нийт	128	64,326.1	43,742.2	208	81,345.0	56,545.7	80	17,018.9	12,803.5

2023 онд хэрэгжих 81,345.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 208 төсөл, арга хэмжээ батлагдсанаас аймгийн хөрөнгө оруулалтаар 76,922.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 160 төсөл, арга хэмжээнд 52,314.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 4,422.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 төсөл, арга хэмжээнд 4,231.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тус тус баталжээ.



Аймаг болон Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээний нийт тоонд эзлэх хувийг хөрөнгө оруулалтын ангиллаар нь авч үзвэл батлагдсан төсвийн 66 хувийг 82 барилга, байгууламжийн ажилд, 16.1 хувийг 55 их засварын ажилд, 13.8 хувийг 44 тоног төхөөрөмж худалдан авах ажилд, 2 хувийг 14 ТЭЗҮ боловсруулахад, 2.1 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанаргүй бусад 12 ажлыг санхүүжүүлэхээр баталжээ. /Дүрслэл№2/

Харин

хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөгт эзлэх хувийг хөрөнгө оруулалтын ангиллаар нь авч үзвэл батлагдсан төсвийн 68 хувь буюу 55.0 тэрбум төгрөгийг барилга байгууламжид, 16.7 хувь болох 13.1 тэрбум төгрөгийг их засварт, 13.8 хувь 11.2 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж, 2 хувь буюу 1.7 тэрбум төгрөгийг ТЭЗҮ, 0.1 хувь 0.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын шинж чанар агуулаагүй бусад ажлыг санхүүжүүлэхээр баталжээ. /Дүрслэл№3/



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулсан 2023.07.04-ний өдрийн 12/05 дугаар тогтоолоор 5 ажилд олгох санхүүжилтэд 521.9 сая төгрөгийг нэмж олгохоор, 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г хасаж, шинээр хэрэгжүүлэх 9,112.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 ажил, 2022 онд үүссэн 16 ТАХ-д 1,793.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор, нийт 11,128.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Харин 2023.10.16-ний өдрийн 14/02 тогтоолоор 2,322.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-г жагсаалтаас хасаж, шинээр 5 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусган хөрөнгө оруулалтын жагсаалтад өөрчлөлт оруулсан байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтыг аймгийн ИТХ-д алдаатай төлөвлөж өргөн мэдүүлснээс төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан 2023 оны 12/05, 14/02 тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын жагсаалтын төсөвт өртгийг зөрүүтэй батлуулсан байна.

Замын-Үүд сумын ЗДТГ-ын ХБТ-аас хөрөнгө оруулалтын жагсаалтыг алдаатай боловсруулж сумын ИТХ-д өргөн мэдүүлснээс төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан 2023 оны 10/60, 14/02, 12/69 тоот тогтоолын хавсралтын хөрөнгө оруулалтын жагсаалтын төсөвт өртөг, 2023 онд санхүүжих дүнг зөрүүтэй, 12/69 тоот тогтоолын хавсралтаар жагсаалтад тодотголоос өмнө хэрэгжсэн ТАХ-үүдийг хасаж батлуулсан байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй нийт 1,183.9 сая төгрөгийн ажлыг тусгаж батлуулсан байна.

ОНХО-ын төлөвлөгөөнд ТАХ-ний хэрэгцээ шаардлага, хэрэгжих хугацаа, бусад хүчин зүйлсийг уялдуулж төлөвлөснөөр нэн тэргүүнд шаардлагатай ажлыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн өр төлбөрийн тодорхой хэсгийг барагдуулахаар байна.

Аймгийн Засаг дарга нь сумдын ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид авах арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийн дагуу ОНХС болон бусад эх үүсвэрээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ХО-ыг харгалзан үзсэнээр сумын дэд бүтцийг сайжруулах, цахилгаан, дулааны шугам сүлжээ, орчны тохижилт, төсөл хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах, хүн малын усан хангамж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг холбогдох журмын дагуу малын тоо толгойн албан татварын орлого, сумын ОНХС, хөтөлбөр арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөхөд чиглүүлбэл ОНХО-аар томоохон ТАХ-г төлөвлөн хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг үр дүнтэй зарцуулах боломж бүрдэхээр байна.

Дорноговь аймгийн 2023 оны худалдан авах ажиллагааны цахим төлөвлөгөөнд 69.8 тэрбум төгрөгийн 146 төсөл арга хэмжээ зарлахаар батлагдсанаас 6.1 тэрбум төгрөгийн 61 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж, 8.9 тэрбум төгрөгийн 12 төсөл арга хэмжээ цуцлагдаж, 54.8 тэрбум төгрөгийн 73 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулан, гэрээ байгуулах эрх олгосон байна.

Мөн Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 4,422.2 сая төгрөгийн 48 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан, 4 төсөл, арга хэмжээ цуцлагдсан байна. /Хүснэгт №3/

2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны мэдээлэл

Төсөв захирагч	Худалдан авах ажиллагааны төрөл	Төсөл, арга хэмжээн ий тоо	Шалгару улсан	Амжилтгүй болсон Төсөл, арга хэмжээний	
				Тоо	Тайлбар
Аймаг	Нээлттэй тендер шалгаруулалт	68	57	11	Хүчингүй болсон 5, дахин зарлах 3, оролцогч байхгүй 1, гомдол гаргасан 1
	Харьцуулалт арга	12	12	0	-
	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	5	4	1	Захиалагчаас хүчингүй болгосон
Замын-Үүд сум	Нээлттэй тендер шалгаруулалт	13	11	2	Тендерийн үнээс өндөр үнийн санал ирүүлсэн
	Харьцуулалт арга	14	12	2	Тендер цуцлагдсан
	Шууд гэрээ байгуулах	18			-
Нийт		130	96	14	

Өмнө оноос шилжин хэрэгжих ТАХ-ний санхүүжих дүнг хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгаж ИТХ-аар батлуулсан байгаа ч төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бодитой тооцоогүй олон ТАХ-г нэмэлтээр хэрэгжүүлэхээр баталсан нь өмнө оноос шилжин хэрэгжсэн, мөн шинээр батлагдан хэрэгжиж дууссан ТАХ-ний санхүүжилтийг бүрэн олгох боломжгүй болж, өр үүссэн байна.

А.4. Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хянахгүй санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 208 ТАХ-ээс 194 ажлыг хэрэгжүүлж, санхүүжилтэд нийт 41,518.2 сая төгрөгийг олгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2023.10.16-ны өдрийн 14/02 дугаар тогтоолоор шинээр хэрэгжих 131 ажилд 37,759.3 сая төгрөг, 2022 оноос шилжин хэрэгжих 9 ТАХ-г 8,367.3 сая төгрөг, 2022 онд үүссэн өр төлбөр 16 ТАХ-г 1,793.5 сая төгрөг, өмнө оноос шилжин хэрэгжих УТХО-ын 4 ТАХ-г 4,402.1 сая төгрөг, нийт 160 ТАХ-г 52,322.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, хэрэгжүүлсэн 150 ажлын санхүүжилтэд 38,055.7 сая төгрөгийг олгосон байна.

Замын-Үүд сумын ИТХ-ын 2023.12.11-ний өдрийн 12/69 дугаар тогтоолоор шинээр хэрэгжих 48 ТАХ-ний санхүүжилтэд 4,422.1 сая төгрөгийг баталж, хэрэгжсэн 44 ажлын санхүүжилтэд 3,979.1 сая төгрөгийг олгосон байна. /Хүснэгт №5/

ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт

Төсөв захирагч	Төлөвлөлт	Төсөл, арга хэмжээний тоо	2023 онд санхүүжүүлэх дүн	/сая төгрөг/	
				Олгосон санхүүжилт	Гүйцэтгэлийн хувь
Аймаг	Шинэ	131	37,759.3	26,148.2	68.7
	2022 оноос шилжих	9	8,367.3	7,205.7	82.1
	2022 оны өр төлбөр	16	1,793.5	946.8	52.8
	УТХО-д олгосон	4	4,402.1	3,755.0	85.3
	Дүн	160	52,322.1	38,055.8	73.0
Замын-Үүд сум	Шинэ	48	4,422.1	3,462.4	78.0
	Дүн	48	4,422.1	3,462.4	78.0
Нийт дүн		208	56,744.2	41,518.2	73.1

Аймаг болон Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлсэн ажлуудад олгосон санхүүжилтийн хэмжээ, хувийг хөрөнгө оруулалтын төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-д олгосон санхүүжилт /ТАХ-ний ангиллаар/

Дүрслэл №4



Дүрслэл №5



Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 160 ТАХ-ний санхүүжилтэд 52,314.7 сая төгрөгийг 2023 онд олгохоор баталсан боловч орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой 150 хэрэгжсэн ажлын санхүүжилтэд 38,055.8 сая төгрөгийг олгож, өмнө оноос шилжин хэрэгжсэн болон аудитад хамрагдах хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-ний санхүүжилтэд 3,022.4 сая төгрөгийг дууту олгосон байна.

Аудитад хамрагдсан хугацаанд олгосон нийт 41,518.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлийн баримттай тулгахад гүйцэтгэлийг бүрэн хянаагүй, зохиогч, захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ажлыг санхүүжүүлсэн, урьдчилгаа санхүүжилтийг 30 хувиас хэтрүүлэн олгосон зэрэг зөрчлийг гаргасан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн ТАХ-ний санхүүжилт 18.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 248.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, гэрээний хугацаанд хэрэгжээгүй 2 ТАХ-ний санхүүжилтэд 110.6 сая төгрөгийг урьдчилан олгосон боловч хөрөнгө оруулалтын зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь хүлээн авсан ч зарим ажил зураг, төсвийн дагуу хийгдээгүй байна.

Б.1. Бүрэн хэрэгжиж дууссан зарим төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлээгүй байна.

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т “Барилга байгууламж нь зураг төслийн дагуу баригдсан байх”, МУ-ын Иргэний тухай хуулийн 350.1-т “Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх үүрэг хүлээж, захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчиж дараах ажлуудыг зураг, төсвийн дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- 854.1 сая төгрөгийн өртөгтэй Дэлгэрэх сумын ЭМТ-ийн өргөтгөлийн барилга,

- 240.5 сая төгрөгийн өртөгтэй Дэлгэрэх сумын цаг уурын барилга,
- 405.2 сая төгрөгийн өртөгтэй Дэлгэрэх сумын төвд нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажил,
- 81.6 сая төгрөгийн өртөгтэй Ахмадын сувиллын үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах ажил, Багц-2

Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн төсвийн тооцоог мэргэшлийн зэрэгтэй төсөвчнөөр хийлгэсэн байна”, 40 дүгээр зүйлийн 40.2-т “Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж дараах ТАХ-г хэрэгжүүлж, санхүүжилт олгосон байна.

- 63.2 сая төгрөгийн өртөгтэй Замын-Үүд сумын Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын агуулахын зориулалттай далд зоорь барих ажил
- 50.0 сая төгрөгийн өртөгтэй Сайншанд сумын Төв цэцэрлэгт хүрээлэнгийн мод, зүлэгжүүлэх ажил

Аймаг, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 208 ТАХ-ээс 196 ажлыг 2023 онд хэрэгжүүлэхээр, 12 ажлыг 2024 онд шилжүүлэн хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс 2023 онд 167 ажлыг гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлж, дуусаагүй 27 ажлыг он дамжин хэрэгжүүлэхээр гэрээг сунгасан байна.

Төсвийн тодотголоор батлагдсан ажлуудаас 263.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил бүрэн хэрэгжиж, 375.0 сая төгрөгийн ажлыг гэрээний хугацаанд хэрэгжүүлсэн боловч чанаргүй ажил хийгдсэн, 2,277.5 сая төгрөгийн ажлыг он дамжин хэрэгжүүлэх гэрээ байгуулж, 1,807.0 сая төгрөгийн ажлын тендер зарласан хугацаа нь он дамжиж нээгдэхтэй холбоотой 2023 онд гэрээ байгуулах боломжгүй болсон байна.

ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний тодорхой хэсгийг чанаргүй хийгдсэн ажлууд эзэлж байгаа бөгөөд зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгч компаниуд чанаргүй гүйцэтгэсэн ажлыг хуульд заасны дагуу засварлах үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас хөрөнгө оруулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Б.2. Аймгийн хэмжээнд 2023 онд хэрэгжсэн нийт ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагын 4 ажилтан хяналт хэрэгжүүлсэн байгаа нь захиалагчийн хяналтыг чанартай хэрэгжүүлэх боломж бүрдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга ГХБХБГ-тай захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, тус албаны 1 мэргэжилтэн, гэрээт 3 инженер хэрэгжүүлсэн байна.

Захиалагчийн хяналтын зардлын санхүүжилтийн 70 хувь 41.9 сая төгрөгийг ГХБХБГ, 30 хувь 2.9 сая төгрөгийг аймгийн ЗДТГ, Зам тээврийн хөгжлийн төвд 86.5 сая төгрөг, Сайншанд сумын ХЗАА-нд 18.9 сая төгрөг, гэрээт хяналтын инженер Л.Лхамсүрэнд 20.7 сая төгрөг, нийт захиалагчийн хяналтын зардалд 170.9 сая төгрөгийг олгосон байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзэхэд мэргэжлийн боловсон хүчний тоо цөөн, хяналт тавих ажлын тоо их, хяналт хэрэгжүүлэх байршил алслагдсан зэргээс шалтгаалж захиалагч хэрэгжиж байгаа ТАХ-ний гүйцэтгэгч, зохиогч, захиалагчийг хамруулсан “Telegram group” үүсгэн ажлын явцын талаар тухай бүр мэдээлэл солилцож, үе шатны ажлын явцыг цахимаар хянаж, хяналт хийх тухай бүрд талбайн журналд өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг тэмдэглэсэн, цөөн тоогоор

талбарт очиж хяналтыг хэрэгжүүлсэн байгаа нь захиалагчийн хяналтыг чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.

Б.3. Хэрэгжүүлж дууссан 1,938.1 сая төгрөгийн өртөгтэй, 10 ТАХ-г НББ-д тусгаагүй байна.

ОХНО-аар 2023 онд 79,044.7 сая төгрөгийн өртөгтэй 167 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжиж дууссан ба аймгийн Орон нутгийн өмчийн газар нь хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс 1,938.1 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ холбогдох байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгагдаагүй байна.

БҮЛЭГ В. Хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнг хэмжигдэхүйц байдлаар төлөвлөөгүйгээс хүрсэн үр дүнг харьцуулж үнэлэх боломжгүй байна.

В.1. ОНХО-аар хэрэгжүүлсэн ажлын бодит хэрэгцээ шаардлагыг үнэлж, төлөвлөх шаардлагатай байна.

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.1-т заасан төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж, ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг үнэлж төлөвлөөгүйгээс ОНХО-ын санхүүжилтийг үр ашиггүй зарцуулах эрсдэл байна.

В.2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн хүрэх үр дүнг үнэлж, хэмжих боломжтой байдлаар төлөвлөөгүй байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлуулахдаа ТАХ бүрийн хүрэх үр дүнг төлөвлөж хүргүүлээгүй байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ч зорилтот түвшний хүрэх үр дүнг тоон ба чанарын үзүүлэлтээр хэмжигдэхүйц, тодорхой байдлаар тусгаагүйгээс хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөсөн болон хүрсэн үр дүнг хэмжиж харьцуулах боломжгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ОНТХО-аар 2023 онд 64,326.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 128 төсөл, арга хэмжээ, төсвийн тодотголоор 80 ТАХ-г нэмж, нийт 81,345.0 сая төгрөгийн өртөгтэй 208 ажлыг хэрэгжүүлэхээр баталж, 194 ТАХ-ний санхүүжилтэд 41,518.2 сая төгрөгийг олгосноос 71.2 хувь 29,567.9 сая төгрөгийг шинээр хэрэгжих ажилд, 26.4 хувь 10,960.8 сая төгрөгийг өмнө оноос шилжин хэрэгжих ажилд, 2.4 хувь болох 946.7 сая төгрөгийг 2022 оны өр төлбөрт олгосон байна.
- Аймгийн ХО-аар 2023 онд хэрэгжүүлэх 160 ТАХ-ний санхүүжилтэд 52,314.7 сая төгрөгийг олгохоор баталсан ч орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс 38,055.8 сая төгрөгийг санхүүжүүлэн, өмнө оноос шилжин хэрэгжсэн, бүрэн хэрэгжиж дууссан ТАХ-ний санхүүжилтэд нийт 3,022.4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, хөрөнгө оруулалтын зардлын өр үүссэн байна.
- Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр болон он дамжин хэрэгжүүлэхээр баталсан 160 ТАХ-г дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд бүрэн тусгасан ч жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 50 ТАХ-г АИТХ-аар тодотгож батлуулсан байна.
- Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 48 ТАХ-ээс 37 нь дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан, тусгагдаагүй 11 арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт ТАХ-ний хэрэгжилтийн хүрэх үр дүнг үнэлж, хэмжихүйц байдлаар төлөвлөөгүй, мөн төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй, техникийн нөхцөл олгогдоогүй, төсөв батлагдсанаас хойш зураг төсөв боловсруулагдсан, мөн зураг, төсөвгүй нийт 58 ТАХ-г төлөвлөж батлуулсан байна.
- Аймаг, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын жагсаалтад орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, хувийн өмчид шилжих, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн нийт 1,183.9 сая төгрөгийн ажлыг тусгаж батлуулсан нь төлөвлөлтийн үр дүнд чиглэсэн байх зарчмыг хангаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын жагсаалтыг аймаг, сумын ИТХ-д алдаатай төлөвлөж өргөн мэдүүлснээс ИТХ-ын тогтоолын хавсралтын нийт төсөвт өртөг, 2023 онд санхүүжүүлэх дүнг зөрүүтэй тусгаж батлуулсан байна.
- Аймгийн хэмжээнд төсвийн тодотголоор 80 ажлыг нэмж баталсан нь тендер зарлах хугацаа оройтож, тендер нээх хугацаа он дамжсан, богино хугацаанд чанаргүй ажил хийгдсэн байна.
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч гүйцэтгэгч зарим компани 3-10 тендерт шалгарч, давхацсан хугацаанд олон ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, богино хугацаанд хэрэгжүүлснээс зарим ажил чанаргүй хийгдэж, гэрээний хугацаанд хэрэгжээгүй байна.
- Аймгийн Наадмын талбайн гадна цахилгаан хангамжийн 122.0 сая төгрөгийн ажил, Замын-Үүд сумын 1 дүгээр зуухыг буулгах, шилжүүлэх, шинэчилж

засварлах 40.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг хэд хэдэн ажилд хувааж баталснаас ХАА-д тендер шалгаруулалтын холбогдох аргыг мөрдөөгүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5 дахь заалтыг зөрчсөн байна.

- Аймгийн ХО-аар хэрэгжүүлсэн зураг төсөвгүй, зураг, төсвийн дагуу хийгдээгүй, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлээгүй 5 ТАХ, Замын-Үүд сумын ХО-аар хэрэгжүүлсэн гэрээний хугацаа дууссан, ажил хийгдээгүй, зураг төсөвгүй 3 ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэхгүй олгосон байна.
- Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 18.0 сая төгрөгийн өртөгтэй Даланжаргалан сумын Соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах ажлын санхүүжилтийг аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээс олгосон байна.
- Аймгийн ХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-ний зохиогчийн хяналт хийх гэрээнд тусгагдсан үүргийг бүрэн биелүүлсэн эсэхийг үнэлэхгүйгээр 80.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардлаас олгосон, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 9 ТАХ-ний төсөвт 13.7 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардал тусгагдсан боловч зохиогчтой гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн боловсон хүчний тоо цөөн, хяналт тавих ажлын тоо олон, ТАХ хэрэгжиж байгаа байршил алслагдсан зэрэг нөхцөлүүд нь хяналтыг тогтмол, чанартай, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд нөлөөлсөн байна.
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 онд ОНТХО-ын төлөвлөлт, зарцуулалтад хяналт шалгалт хийгээгүй, дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.
- Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгчээр бүрэн хангуулаагүйгээс чанаргүй хэрэгжүүлсэн 3,494.5 сая төгрөгийн өртөгтэй 11 ТАХ-г ашиглалтад авсан байна.
- Аймгийн ХО-аар 2023 онд бүрэн хэрэгжүүлж дууссан 1,938.1 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар нийт 26,856.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 19.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 5,543.1 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, холбогдох албан тушаалтнуудад зөрчил арилгуулах 21,293.7 сая төгрөгийн 10 зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсвийг боловсруулахдаа санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтлан техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг, төсөв боловсруулагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон, орон нутгийн өмчид бүртгэх боломжтой, хөрөнгө оруулалтын шинж чанартай, бодлогын баримт бичигт тусгагдсан томоохон ажлуудыг цогцоор нь хэрэгжүүлэхээр, ТАХ бүрийн хүрэх үр дүнг үнэлж, хэмжих боломжтой байдлаар төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 12.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 65.1.1-т заасан орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх бүрэн эрхийн дагуу орон нутгийн төсвийн төсөл, түүний тодотголын төсөлд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртөгт орох өөрчлөлтийг үнэн зөв тооцож боловсруулан, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах.
3. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5 дахь заалтад нийцүүлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад ТАХ-ний төсөвт өртгийг хуваан төлөвлөж, батлуулахгүй байх.
4. ОНХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-г ашиглалтад хүлээн авах комиссыг Засгийн газрын 2021 оны 212 тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-д заасан “,,, зураг төсөл, техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн байдал, хяналт хэрэгжүүлсэн захиалагч, зохиогч, техникийн комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан эсэхийг дүгнэж, хэрэгжилтийг бүрэн хангуулан ТАХ-г ашиглалтад оруулах дүгнэлтийг гаргах” гэсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглүүлж, хөрөнгө оруулалтын чанар байдал, үр дүнг нэмэгдүүлэх.
5. Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зохиогчийн техникийн хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, барилга байгууламжийн хийц бүтээц, материалд хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэж баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд өөрийн буруутай үйлдлээс гарсан хохирлыг хариуцах зэрэг зохиогчийн чиг үүргийг чанартай хэрэгжүүлсэн, мөн зохиогчийн хяналт хийх гэрээнд тусгасан хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг дүгнэж, үр дүнд үндэслэн хяналтын зардлыг олгох.
6. ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-нд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.5-д захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх этгээд нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байхаар заасны дагуу шинээр баригдах барилга, байгууламжид захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх багийг нарийн мэргэжлийн инженерүүдээс бүрдүүлэх, аймгийн ГХБХБГ-ын мэргэжлийн боловсон хүчний нөөцөд тохируулан захиалагчийн хяналт хийх ажлыг хариуцуулж, ХО-аар хэрэгжүүлэх ажлын чанарыг сайжруулахад анхаарах.

7. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан ТЕЗ-ийн дэргэдэх дотоод аудитын байгууллага нь ОНХО-аар хийгдсэн ТАХ-ний үр дүнд санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах чиг үүргийн дагуу СХДАА-ны хяналт шалгалтын төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлэх чиглэл өгч, хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах.

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.АНХБАЯР ТАНАА:

1. Сумын хөрөнгө оруулалтын төсвийг боловсруулахдаа санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтлан техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг, төсөв боловсруулагдсан, хуульд заасан зөвшөөрөл олгогдсон, орон нутгийн өмчид бүртгэх боломжтой, хөрөнгө оруулалтын шинж чанартай ТАХ-г төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 12.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.
2. Төсвийн тухай хуулийн 66.1.1-т заасан орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаарх бүрэн эрхийн дагуу орон нутгийн төсвийн төсөл, тодотголын төсөлд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төсөвт өртөгт орох өөрчлөлтийг үнэн зөв тооцож, ажлын тоо хэмжээг бүрэн тусган боловсруулж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах.
3. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.5 дахь заалтад нийцүүлж сумын хөрөнгө оруулалтын жагсаалтад ТАХ-ний төсөвт өртгийг хуваан төлөвлөж, батлуулахгүй байх.
4. Сумын ХО-аар хэрэгжих ТАХ-ний гүйцэтгэлд Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан зохиогчийн чиг үүргийг хяналт хийх гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, чанартай барилга байгууламж баригдах нөхцөлийг бүрдүүлэх.

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.ТҮВШИНТӨР ТАНАА:

1. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 “Барилга байгууламж нь зураг төслийн дагуу баригдсан байх” гэсэн заалтыг мөрдөж, зураг төсөвгүй ажил хэрэгжүүлэхгүй байх, аймгаас эрх шилжүүлсэн ТАХ-г чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.САРУУЛЦОГТ ТАНАА:

1. ОНХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний тендерийн баримт бичигт ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14 дүгээр зүйлд заасан ерөнхий нөхцөлд магадлахаар тусгасан сүүлийн 3 жилийн хугацаанд ХАА-д оролцохдоо гэрээний үүргээ биелүүлсэн байдал, тендерт оролцогчийн хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг гаргуулахаар тусгайлан зааж, ТАХ-г хугацаанд нь чанартай хэрэгжүүлэх үүднээс компаниудыг олон ТАХ-г зэрэг гүйцэтгүүлэхгүй байх бодлогыг баримтлах.